

**“ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИ**

| <b>Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/</b>   |  |
|--|--|
| <i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i> |  |
| <i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/</i>  | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2024 оны 6 дугаар сарын 30-ний өдөр   |
| <i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>  | “Хархорин” ХК<br>Улсын бүртгэлийн дугаар: 1010001006<br>Үнэт цаасны код: ННН<br>Утасны дугаар: 99993800, 99113633  |
| <i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>  | Монголын хөрөнгийн бирж  |
| <i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>  | Хөдөө аж ахуй, газар тариалан<br>Чацаргана тариалах, чацаргана болон бусад модлог ургамлын суулгац бойжуулах   |
| <i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>   | 539,515 ширхэг   |
| <i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>   | Б.Ганбат<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга   |
| <i>1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>  |  |
| <i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>   | Эргэлтийн хөрөнгийн дүн – 6,305.6 сая төгрөг<br>Эргэлтийн бус хөрөнгийн дүн – 2,766.7 сая төгрөг<br><b>Нийт хөрөнгийн дүн - 9,072.3 сая төгрөг</b><br>Богино хугацаат өр төлбөрийн дүн – 10,431.7 сая төгрөг<br>Урт хугацаат өр төлбөрийн дүн - 0.0 сая төгрөг<br><b>Өр төлбөрийн нийт дүн – 10,431.7 сая төгрөг</b><br>Эзэмшигчдийн өмчийн дүн - (1,359.4) сая төгрөг<br><b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн - 9,072.3 сая төгрөг</b> |

|  |   |  |
|--|---|--|
|  | <i>Орлогын тайлан</i>   | Үйл ажиллагааны орлого – 15.4 сая төгрөг<br>Борлуулалтын өртөг – 15.6 сая төгрөг<br><b>Нийт ашиг (алдагдал) – 0.2 сая төгрөг</b><br>Бусад орлого - 63.4 сая төгрөг<br>Бусад зардал – 119.2 сая төгрөг<br><b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) - (55.9) сая төгрөг</b><br><b>Татварын дараах ашиг (алдагдал) - (55.9) сая төгрөг</b>                  |
|  | <i>Өмчийн оорчлолтийн тайлан</i>  | Өмч - 836.2 сая төгрөг<br>Хуримтлагдсан ашиг - (2,195.6) сая төгрөг<br><b>Нийт дүн - (1,359.4) сая төгрөг</b>  |
|  | <i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>   | <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b><br>Мөнгөн орлогын дүн - 74.0 сая төгрөг<br>Мөнгөн зарлага – 73.9 сая төгрөг<br><b>Цэвэр мөнгөн гүйлгээ – 0.1 сая төгрөг</b>   |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b><br>Мөнгөн орлогын дүн - 0.0 сая төгрөг<br>Мөнгөн зарлага - 0.0 сая төгрөг<br><b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - 0.0 сая төгрөг</b> |   |  |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b><br>Мөнгөн орлого - 0.0 сая төгрөг<br>Мөнгөн зарлага - 0.0 сая төгрөг<br><b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - 0.0 сая төгрөг</b>                      |   |  |
| <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ 0.1 сая төгрөг</b>   |   |  |
| 2.   | <i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>  |  |
|  | “Хархорин” ХК-ийн 2024 оны 06-р сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдал, тухайн хагас жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартуудын дагуу үнэн зөв гаргасан. |  |
| 3.   | <i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>   |  |
| 3.1.   | <i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>  | 2024 оны 06-р сарын 30-ны байдлаарх санхүүгийн харьцаанууд: <ul style="list-style-type: none"> <li>• Нийт хөрөнгийн өгөөж /ROA: -0.006</li> <li>• Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/: -0.067</li> <li>• Нийт хөрөнгийн эргэц /ROTA/: 0.002</li> <li>• Нэгж хувьцааны өгөөж /EPS /: -103.7</li> <li>• Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio): -13.1</li> </ul> |
| 3.2.   | <i>Хорвох чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>  | <ul style="list-style-type: none"> <li>• Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа: 0.06</li> <li>• Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа: 0.00</li> </ul>  |

|      |  |   |
|------|--|---|
| 3.3. | <p><i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i></p>                                       | <p>Үнэт цаас гаргагч нь Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд өөрийн мод бойжуулгын аж ахуйн үйл ажиллагааг идэвхжүүлэн Монгол орны уур амьсгалд дасан зохицсон төрөл бүрийн модлог ургамлын суулгацуудыг санал болгож байгаа. Гэвч 2024 оны эхний хагас жилд борлуулалтын орлого маш муу байсан. Энэ нь 1-рт Тэрбум мод хөдөлгөөний дагуу модны суулгац худалдан авах иргэд, ААН-үүдийн идэвх муу, цөөн тооны суулгац худалдан авч байгаа, 2-рт Хархорин сумын үерийн далангийн байгууламжийг анхнаасаа буруу, алдаатай төлөвлөж барилгын ажлыг гүйцэтгэсэн, энэ нь жил болгон зуны улиралд Хархорин сумын төвөөр хүчтэй бороо ороход үер бууж, үерийн далан ачааллаа дийлэхгүй “Хархорин” ХК-ийн усжуулалтын сувгийг лаг шавар, шороо, хогоор дүүргэж гэмтээж бөглөдөг. Ийнхүү сувгийн ажиллагаа зогссоноос болж чацаргана, мод бойжуулгын аж ахуйнуудын усалгаа доголдож, асар их хэмжээний алдагдал хүлээж байна.</p> |
| 3.4. | <p><i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i></p>   | <p>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагч нь өөрийн санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ хийгээгүй болно.</p>  |
| 4.   | <p><i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i></p> |   |
|      | <p>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээнийхэд тооцогдох хэлцэл хийгээгүй болно.</p>  |   |
| 5.   | <p><i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжигч эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i></p>   |   |
|      | <p>“Хархорин” ХК нь тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас гаргаагүй болно.</p>   |   |
| 6.   | <p><i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i></p>   |   |
|      | <p>“Хархорин” ХК нь тайлант хугацаанд өөрийн үйл ажиллагаандаа Компанийн засаглалын кодекс, үүнтэй холбогдуулан гаргасан дотоод дүрэм журмуудыг баримтлан ажилласан болно.</p>   |   |
| 7.   | <p><i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i></p>  |   |

Тайлант хугацаанд “Хархорин” ХК-ийн 5% ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн өөрчлөлт гараагүй болно.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2024 оны 04-р сарын 08-ний өдрөөр тасалбар болгож гаргуулсан хувьцаа эзэмшигчдийн судалгааны дагуу “Хархорин” ХК нь нийт 584 хувьцаа эзэмшигчтэй, үүнээс:

1. Иргэн С.Пүрэв - 377,660 (70.0%)
2. Монгол Улсын хуулийн этгээд “Селус номадс” ХХК - 102,521 ш (19.0%)
3. бусад жижиг хувьцаа эзэмшигчид 582 хувь хүн, ААН байгуулагад нийт 59,334 ш хувьцаа (11%)

“Хархорин” ХК нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2024 оны 04-р сарын 27-ны өдөр компанийн оршин байгаа хаягаар хуралдуулсан. Хурлын мэдэгдлийг 2024 оны 03-р сарын 18-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн. Хурлын материалыг 2024 оны 04-р сарын 30-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтүүдийг хэлэлцэн баталсан.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн баталсан.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохгүй байхаар шийдвэрлэсэн.

Бусад асуудал хэлэлцээгүй болно.

Тус хурлаас гарсан шийдвэрүүдтэй Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Пүрэвийн УЧРАЛ

Албан тушаал: “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг гур орлон гүйцэтгэгч

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)



Овог, нэр: .....

Албан тушаал: “.....” ХХК-ийн захирал

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Баттогтох Ганбат

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: .....

Огноо: 2024.07.18